

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР /№02/

2025 оны 01 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх байгууллага	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хугацаа
2025 ОНЫГ “БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД			
1.	Худалдан авах ажиллагааны алба	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх ажлуудын бэлтгэлийг сайтар хангаж, худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулах.	Ажлын 4 хоног
2.	Газар зохион байгуулалтын алба	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хүрээнд газар чөлөөлөлтийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах.	Ажлын 4 хоног
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД			
3.	Онцгой байдлын хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд “Шуурхай штаб”-ыг шаардлагатай мэдээ, мэдээллээр түргэн шуурхай хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах.	Ажлын 4 хоног
4.	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Хүнсний, бараа, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, стандарт, сав баглаа боодлыг бэтүүмж, шаардлага хангуулах, аюулгүй байдлыг хяналт шалгалтын ажлуудыг шуурхай зохион байгуулах.	Ажлын 4 хоног
5.	Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс	Ерөнхий боловсролын хичээлийг эхэлж байгаатай холбогдуулан томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, сургалтын байгууллагын суралцагч, багш, ажилтан, албан хаагчдыг дотоод орчинд амны хаалтыг тогтмол зүүлгэх, мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэх, захирамж гаргах.	Ажлын 4 хоног
6.	Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн хөгжлийн хэлтэс	Эрүүл мэндийн байгууллагуудын гадна орчны аюулгүй байдал болон дотоод орчны угаалга, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгч устгалын үйл ажиллагаанд онцгой анхаарч, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллах.	Ажлын 4 хоног
ЦАГИЙН ҮЕИЙН БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД			
7.	Газар зохион байгуулалтын алба, Онцгой байдлын хэлтэс	Засгийн газраас ХУД-т Гал түймэр унтраах аврах анги барих шийдвэр гарсантай холбогдуулан газрын асуудлыг шийдвэрлэх.	Ажлын 4 хоног

8.	Хууль, эрх зүйн хэлтэс	Нийслэлийн теле камерын нэгдсэн төвийн ажлыг эрчимжүүлж, дүүргүүдийн дэд төвүүдийг холбогдох ажлуудаа шуурхай зохион байгуулж ажиллах.	Ажлын 4 хоног
9.	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	“Цагаан сар”-ын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах.	Ажлын 4 хоног
ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД			
10.	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хог тээврийн байгууллагууд	Нийслэлийн хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг эрчимжүүлж, танилцуулах.	Ажлын 4 хоног
11.	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хог тээврийн байгууллагууд	Ил задгай хог хаягдал хөглөрч, хүмүүсийн эрүүл, цэвэр орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаатай холбоотой хог хаяхыг хориглосон цагийн хуваарийг зохицуулсан захирамжийн төслийг боловсруулах.	Ажлын 4 хоног
12.	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ золбин нохой, муур устгах ажлуудаа эрчимжүүлэх, хэрэгжилтэд Захирагчийн ажлын албанаас хяналт тавьж ажиллах.	Ажлын 4 хоног
13.	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Суурьшлын бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд Захирагчийн ажлын алба хяналт тавьж ажиллах.	Ажлын 4 хоног
14.	Газар зохион байгуулалтын алба, Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд хотын стандартыг мөрдүүлэх хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчилтэй аж ахуйн нэгжийн эзэмшлийн зам талбайн газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулах.	Ажлын 4 хоног

Жич: Үүрэг даалгаврын биелэлтийг 2025.01.30-ний өдрийн 12:00 цагаас өмнө /khanuul.1208@gmail.com/
цахим хаягаар хүлээн авна.
МЭРГЭЖИЛТЭН О.ОДЦЭРЭН